



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/232

Улаанбаатар хот

Хүүхдийн төв сувилалын
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/614 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 20,000,000.00 /хорин сая/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Хүүхдийн төв сувилал /Г.Ганчимэг/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Хүүхдийн төв сувилал /Г.Ганчимэг/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Б.Батбаяр/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Н.Мөнхбаатарт тус тус даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000709

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 1119222495 -р тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

/төг/					
д/д	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газар	Уаз-220692-5359 37-19 УНО	20,000,000.00	20,000,000.00	-
Дүн			20,000,000.00	20,000,000.00	-